



УТХО-ын төлөвлөлтийн тогтолцооны талаар:

1. Говь-Алтай аймгийн хэмжээнд 2020 онд УТХО-р эрх шилжиж хэрэгжсэн 9,937.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 ТАХ-г 3,379.0 сая төгрөгөөр, эрх шилжээгүй 306,943.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ-г 86,718.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталжээ.
2. УТХО-аар 2015 оноос 2020 оны хооронд 165 км хатуу хучилттай авто зам, 1 далан, 225.9 км ЦДАШ, 6 шугам сүлжээний ажил, 675 ортой 7 цэцэрлэг, 4080 суудалтай 8 сургууль, 300 ортой 3 дотуур байр, 110 ортой 8 эмнэлэг, 500 суудалтай 2 соёлын төв, 11 төрийн байгууллагын барилга, дэд бүтцийн 8 барилга, байгууламжийг ашиглалтад оруулсан байна. Мөн 19 машин, тоног төхөөрөмж, 35 нэгжид их засвар хийгджээ.

Хүснэгт 1. Говь-Алтай аймагт УТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний судалгаа /хүчин чадал, тоо/94141984

Барилга байгууламжийн ангилал	Хүчин чадал		Ашиглалтад оруулсан барилга байгууламж, ТАХ-ний тоо					Нийт	2021 онд хэрэгжиж байгаа ТАХ	
	хэмжих нэгж	Тоо	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он			2020 он
Хатуу хучилттай авто зам	км	165		1					1	
Далан	у/м					1			1	
ЦДАШ	км	225.9		3	1			1	5	1
Шугам сүлжээ							4	2	6	1
Цэцэрлэг	орны тоо	1395	3			2	1	1	7	6
Сургууль	суудлын тоо	4720			3			3	2	8
Дотуур байр	орны тоо	600		2				1	2	3
Соёлын төв	суудлын тоо	1200			1			1	2	4
Хүн эмнэлэг	орны тоо	132	1	1	1	1	2	2	8	1
Спорт заал									0	8
Төрийн байгууллага				2	2			3	4	11
Цэнгэлдэх хүрээлэн									0	1
Дэд бүтцийн барилга байгууламж				4				4	8	6
Машин, Тоног төхөөрөмж				1	3	2	1	12	19	
Их засвар			1	7	6	5	1	15	35	2
Нийт			4	21	17	4	15	43	114	37

3. УТХО-аар 2020 оноос ЦДАШ-ийн 1, шугам сүлжээ 1, 720 ортой 6 цэцэрлэг, 640 суудалтай 2 сургууль, 300 ортой 3 дотуур байр, 22 ортой 1 эмнэлэг, 700 суудалтай 4 соёлын төв, 2 төрийн байгууллага, цэнгэлдэх хүрээлэн, дэд бүтцийн 6 барилга байгууламж, 2 нэгжид их засварын ажил үргэлжлэн хэрэгжиж байна.
4. Энэ хугацаанд боловсролын салбарт түлхүү хөрөнгө оруулалт хийгдсэн ба шинээр Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль, 10 дугаар цэцэрлэг ашиглалтад оржээ. Боловсролын салбарт 2015-2016 оны хичээлийн жилд нийт 1299 багш, ажилтантай байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 1457 болж 158 ажлын байр нэмэгдсэн байна.
5. Жаргалан сумд уурын зуух ашиглалтад орсноор нийт 13 ажлын байр нэмэгдсэн байна. Мөн усан бассейн баригдсан боловч одоогоор ажлын байр нэмэгдүүлээгүй, улмаар Есөнбулаг сумд 320 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг ашиглалтад орохоор ажлын байр нэмэгдэж нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэхээр байна.
6. ТЕЗ нь 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 183 ТАХ-ний 178,992.4 сая төгрөгийн төсвийн төслийг Сангийн яамд хүргүүлсэн байна. Үүнээс 129,246.7 сая төгрөгийн 144 ТАХ-г хасаж баталжээ. Жагсаалтад батлагдсан ТАХ-ний 48.6 хувь нь ТЕЗ-ийн саналд үндэслээгүй байна.
7. ТЕЗ-ийн саналыг харгалзан үзэлгүйгээр төлөвлөж, санхүүжүүлсэн нь нэг талаар Говь-Алтай аймагт хөрөнгө оруулалт шийдэгдэж байгаа давуу талтай боловч нөгөө талаар хөрөнгө оруулалтын бодлого алдагдаж үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгдэж байна. Тухайлбал:

- ✓ Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 08-07-033/06/12 дугаар бүхий “Барилгын ашиглалтын тухай” дүгнэлтээр “2 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж газрыг дахин төлөвлөлтөд оруулах нь зүйтэй” гэсэн байна. Гэтэл аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээс тус цэцэрлэгт засвар хийх төсвийн төсөл хүргээгүй байхад БШУЯ-ны сайдын багцаас 60.0 сая төгрөгийн засварын зардал батлагдан, аймагт эрх шилжин ирснээр засвар хийгдсэн байна.
- ✓ Мөн аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээс 6 дугаар цэцэрлэгт засвар хийх талаар төсвийн төсөл хүргээгүй байхад БШУЯ-ны сайдын багцаас их засвар хийхээр 46.0 сая төгрөгийн төсөв батлагдан, аймагт эрх шилжин ирснээр засвар хийгдсэн байна. Гэтэл Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 08-07-033/10 дугаар бүхий “Барилгын ашиглалтын тухай” дүгнэлтээр “6 дугаар цэцэрлэгийн барилга ашиглалтад орсноос хойш 54 жил ашиглагдаж, ашиглалтын хугацааны аюулгүй байдлыг хангахгүй болсон тул барилгад үйл ажиллагаа явуулахгүй байх нь зүйтэй” гэсэн байна.



- ✓ Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 08-07-033/08/119 дугаар бүхий “Барилгын ашиглалтын тухай” дүгнэлтээр “Хуучин Алтай чуулгын барилгыг буулгаж газрыг дахин төлөвлөлтөд оруулах нь зүйтэй” гэсэн байна. Гэтэл БШУЯ-ны багцаас 830.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Алтай” чуулгын хуучин барилгыг “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх арга хэмжээний хүрээнд 2020 онд 50.0 сая төгрөгийг батлан, аймагт эрх шилжин ирснээр хэрэгжиж эхлээд байна.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр “цэцэрлэгийн барилгыг буулгаж газрыг дахин төлөвлөлтөд оруулах, барилгад үйл ажиллагаа явуулахгүй байх” гэсэн дүгнэлт гарсан байхад цэцэрлэгийн үйл ажиллагааг хэвийн явуулж байгаа нь хүүхдийн амь нас эрүүл мэндийн аюулгүй байдалд эрсдэл бий болж байна. Иймд аймгийн хэмжээний хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст нэгтгэн зөвхөн санал хүргүүлсэн ТАХ-нд төсөв батлуулан хэрэгжүүлж байвал төсвийн үр өгөөж бий болохоор байна.

8. Аймгийн хэмжээнд 2015-2020 онд боловсрол, эрүүл мэндийн салбарт дараах барилга байгууламж ашиглалтад орсон байна. Үүнд:

- ✓ Говь-Алтай аймгийн Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Чандмань, Есөнбулаг сумд 3120 суудалтай 7 ерөнхий боловсролын сургууль ашиглалтад орж, Дэлгэр, Хөхморьт сумд 640 суудалтай 2 сургууль баригдаж байна.
- ✓ Бигэр, Төгрөг, Тонхил, Тайшир, Эрдэнэ, Цогт, Есөнбулаг сумд 675 орны хүчин чадалтай 7 цэцэрлэг ашиглалтад орж, Халиун, Цээл, Есөнбулаг, Алтай, Дэлгэр, Шарга сумдад 720 орны хүчин чадал чадалтай 6 цэцэрлэг баригдаж байна.
- ✓ Дарив, Дэлгэр, Халиун, Цогт, Цээл, Есөнбулаг сумд 110 орны хүчин чадалтай 7 эмнэлэг баригджээ.

Цаашид Тонхил, Цээл, Есөнбулаг сумд сургууль, Есөнбулаг сумд дотуур байр, Чандмань, Есөнбулаг сумд цэцэрлэг, ЗООНОЗ өвчин судлалын төв болон Тайшир сум, Баянтоорой тосгонд эмнэлгийн барилгыг УТХО-аар төлөвлөх хэрэгцээ, шаардлага байна.

9. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хуучин барилга байгууламжийн хувьд мэргэжлийн хяналтын дүгнэлт гараагүй, дахин үнэлж, ашиглагдах хугацааг сунган санхүүгийн тайландаа бүртгэсэн байна. Иймд ашиглагдахгүй байгаа барилга байгууламжийг сум орон нутагт орлого оруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр судалгаа хийж шийдвэрлэх шаардлагатай байна.

10. Төсвийн тухай хуульд зураг төсөвгүй 24 ТАХ-г баталж, хуульд тусгасны дараа 8 ТАХ-ний зураг төсвийг батлуулжээ. Тухайлбал:

- ✓ Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/
- ✓ Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/
- ✓ Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл, засвар /Говь-Алтай, Бугат сум/
- ✓ Сургуулийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2-р цэцэрлэг/
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 6-р цэцэрлэг/
- ✓ Төгрөг сумын Соёлын төвийн барилгын засварын ажил
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Алтай сум, Соёлын төв/
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Дэлгэр сум, Гуулин тосгон, Сургуулийн барилга/
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Эрдэнэ сум, Сургуулийн дээвэр/
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Тайшир сум, Сургуулийн дотуур байрны засвар
- ✓ БТСГ-ын засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум/
- ✓ Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал /Говь-Алтай, Есөнбулаг сум/
- ✓ Тонхил сумын ЭМТ-ийн барилгын их засвар
- ✓ Жаргалан сумын ЭМТ-ийн барилгын их засвар

11. Барилга, байгууламжийн зураг төслийн зардал болох 5.8 сая төгрөгийг зохиогчид шилжүүлээгүй байна. Үүнд:

- ✓ Сургуулийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 1 дүгээр сургууль/ -1.5 сая төгрөг
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 2-р цэцэрлэг/-0.5 сая төгрөг
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Эрдэнэ сум, Сургуулийн дээвэр/-1.3 сая төгрөг
- ✓ Жаргалан сумын ЭМТ-ийн барилгын их засвар-2.5 сая төгрөг

12. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу газрын зөвшөөрөл гараагүй, техникийн нөхцөл олгогдоогүй байхад ТАХ-г хуульд тусгасан нь тайлант онд бүрэн хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн, инженер геологийн дүгнэлтгүйгээр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн зөрчил түгээмэл байна. Тухайлбал:

- ✓ Газрын зөвшөөрөл олгогдоогүй ТАХ-ний тухайд: Тонхил сумын спорт заалны барилга, Есөнбулаг сумын 8 багт хүүхдийн тоглоомын талбай, Дэлгэр сумын сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух, Есөнбулаг сумын нийтийн тээврийн автобусны буудал.



- ✓ **Техникийн нөхцөл олгогдоогүй ТАХ-ний тухайд:** Тонхил сумын спорт заалны барилга, Ахмадын холбоо, сувиллын барилга, Дарив сумын сургууль, цэцэрлэгийн дэд бүтэц, уурын зуух, Есөнбулаг сумын 8 багт хүүхдийн тоглоомын талбай, Бугат сумын цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлт, Дэлгэр сумын сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух, Есөнбулаг сумын нийтийн тээврийн автобусны буудал.
- ✓ **Инженер геологийн дүгнэлт гараагүй ажлын тухайд:** Тонхил сумын спорт заалны барилга, Ахмадын холбоо, сувиллын барилга, Дарив сумын сургууль, цэцэрлэгийн дэд бүтэц, уурын зуух, Есөнбулаг сумын 8 багт хүүхдийн тоглоомын талбай, Бугат сумын цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлт, Дэлгэр сумын сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух, Цээл сумын цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух, Есөнбулаг сумын нийтийн тээврийн автобусны буудал.

13. Хөрөнгө оруулалтын удирдлагын системд мэдээллийг бүрэн оруулаагүй, мэдээллээр бүрэн хангах боломжгүй байна.

Сангийн яамнаас УТХО-ын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр УТХО-ын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулж санхүүжилтийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”, 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар бүрдүүлсэн байна.

УТХО-ын үйл ажиллагаанд оролцогч талууд эрх зүйн зохицуулалтын дагуу 2020 оны 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахим системийг үйл ажиллагаандаа ашиглахаар байна. Аудитаар Говь-Алтай аймагт хэрэгжүүлэх ТАХ-ний мэдээллийг www.publicinvestment.gov.mn веб хуудсанд бүрэн оруулаагүй, мэдээллийн систем зүгшрээгүй, хангалттай бус байна.

14. Өмнөх онуудад эхэлж он дамжин үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр хуульчилсан 2,166.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 991.3 сая төгрөгийн санхүүжилт авсан 2 ТАХ-г Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тусгахгүйгээр орхигдуулсан нь УТХО-ын үр ашгийг бууруулж, дуусаагүй орхигдсон барилга нэмэгдэх үр дагавартай байна. Үүнд:

- ✓ *Жишиг гудамж, тохижилт /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ нь 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, "Бумбат даваа" ХХК-тай 999.6 сая төгрөгийн гэрээ байгуулаад 849.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн боловч 2020 оны төсөвт үлдэгдэл санхүүжилт 150.0 сая төгрөгийг батлаагүй орхисон.*
- ✓ *Цэцэрлэгийн барилга, 100 ор, /Говь-Алтай, Халиун сум/ ТАХ нь 1,166.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Баянмогод ХХК-тай 787.0 сая төгрөгийн гэрээ байгуулаад 142.1 сая төгрөгийг санхүүжүүлсэн боловч 2020 онд төсөв үлдэгдэл санхүүжилт 644.9 сая төгрөгийг батлаагүй орхигдсон.*

15. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд батлагдсан 9,098.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г үргэлжлүүлэн Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тусгахдаа төсөвт өртгийг нийт 2,051.8 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Тухайлбал:

- ✓ *Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Бигэр сум/ ТАХ-ний төсөвт өртөг 100.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.*
- ✓ *Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Жаргалан сум/ ТАХ-ний төсөвт өртөг 100.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.*
- ✓ *Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Төгрөг сум/ ТАХ-ний төсөвт өртөг 100.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.*
- ✓ *Сургуулийн барилга, спорт заалны барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум, Эрүүл мэндийн шинжлэх ухааны Их сургуулийн харьяа Анагаах ухааны коллеж/ ТАХ-ний төсөвт өртөг 745.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.*
- ✓ *Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/ ТАХ нь анх батлагдсан төсөвт өртгөөс 1,006.6 сая төгрөгөөр нэмэгдсэн.*

Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааны талаар:

16. Монгол Улсын Төсвийн тухай хуульд тусгагдсан ч хэрэгжээгүй 671.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ байна. Үүнээс 4 ТАХ нь эрх шилжүүлэх шийдвэртэй холбоотой гэх тайлбарыг холбогдох байгууллагаас өглөө.



Хүснэгт 2. Төсвийн хуульд баталсан ч хэрэгжээгүй ТАХ /сая төгрөг/

Д Д	Хуулийн н дугаар	ТЕЗ	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Хэрэгжээгүй шалтгаан
1	II.1.1.20	МУЕС	Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/	200.0	Сангийн яамнаас шинээр худалдан авах ажиллагаа явуулах шийдвэр ирүүлсэн. Эрх шилжүүлсэн шийдвэр 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр гарсан
2	II.1.3.3	МУЕС	Усан бассейны барилгын тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/	90.0	Эрх шилжүүлсэн шийдвэр 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр гарсан
3	XI.1.91	БХБС	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Улсын хэмжээнд/	71.6	Эрх шилжүүлсэн шийдвэр 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр гарсан
4	XI.2.59	БХБС	Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл, засвар /Говь-Алтай, Бугат сум/	15.0	Эрх шилжүүлсэн шийдвэр 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр гарсан
5	XII.1.1.3 09	БШУС	Шинээр баригдсан сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Дэлгэр сум/	200.0	Эрх шилжүүлсэн шийдвэр 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гарсан. ХАА зарласан боловч оролцогч ирээгүй тул дахин зарлахаар шийдвэрлэсэн. ЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу санхүүжилт зогсоосон тул хэрэгжээгүй
6	XII.3.1.4	БШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Төгрөг сум, Соёлын төвийн барилгын засвар/	40.0	Эрх шилжүүлсэн шийдвэр 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдөр гарсан. 2 удаа ХАА-г зарласан боловч оролцогч оролцоогүй. ЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу санхүүжилт зогсоосон тул хэрэгжээгүй
7	XII.3.1.4	БШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, БТСГ-ын их засвар/	55.0	Эрх шилжүүлсэн шийдвэр 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдөр гарсан. ЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу санхүүжилт зогсоосон тул хэрэгжээгүй
			Нийт дүн	671.6	

- Тайлант хугацаанд шинээр хэрэгжүүлэх 35 ТАХ-ний 17 буюу 48.4 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 12 буюу 34.3 хувийг харьцуулалтын аргаар тус тус зохион байгуулж, 1 буюу 3 хувьд шууд гэрээ байгуулан 5 буюу 14.3 хувьд нь худалдан авах ажиллагаа зарлаагүй байна. Худалдан авах ажиллагааг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 26 ТАХ буюу 90.0 хувийг цахимаар зохион байгуулжээ.
- Сангийн сайдын 2013 оны 215 дугаар тушаалаар батлагдсан “тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан заавар маягтын дагуу тендерийн баримт бичгийг боловсруулсан боловч зураг төсөлгүйгээр 9 ТАХ-ний тендерийг зарласан байна. Энэ нь ТАХ-г магадлалаар баталгаажсан зураг төсөлгүйгээр, тойм дүнгээр төсөвт өртгийг баталж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас шалтгаалсан бөгөөд цаашид улсын төсвөөс үр ашиггүй зардал гарах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлжээ.

ТАХ-ний гэрээний хэрэгжилтийн талаар:

- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Говь-Алтай аймагт 9,937.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3,379.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 36 ТАХ-ээс 3,558.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,069.97 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 18 нь бүрэн хэрэгжсэн, 5,750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 637.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 10 ТАХ нь хэрэгжилт дутуу, 671.6 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй 7 ТАХ нь хэрэгжээгүй байна.
- Хэрэгжилт дутуу ТАХ-ний хувьд 8 нь 2021 онд үргэлжлэхээр байгаа бол 2 нь 2020 онд дуусахаар хуульд тусгасан байна. Тайлант онд дуусах 2 ТАХ нь МУЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу боловсролын салбарын санхүүжилтийг ковидын улмаас түр зогсоосон байсан тул гүйцэтгэгч санхүүжилт аваагүй шалтгаанаар хугацаандаа хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- ✓ Сургуулийн дотуур байрны засварын ажил /Говь-Алтай, Тайшир сум/
- ✓ Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/

- Хэрэгжээгүй ТАХ-ний 71.4 хувь буюу 5 нь ХАА зохион байгуулагдаагүйгээс, 58.5 хувь буюу 2 нь ХАА хүчингүй болсноос шалтгаалсан байна. Тухайлбал:

- ✓ Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/ ТАХ нь Сангийн яамнаас шинээр худалдан авах ажиллагаа явуулах шийдвэр ирүүлсэн.
- ✓ Усан бассейны барилгын тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/-Эрх шилжүүлсэн шийдвэр оны төгсгөлд ирсэн.
- ✓ Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Улсын хэмжээнд/-Эрх шилжүүлсэн шийдвэр оны төгсгөлд ирсэн.
- ✓ Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл, засвар /Говь-Алтай, Бугат сум/-Эрх шилжүүлсэн шийдвэр оны төгсгөлд ирсэн.



- ✓ Шинээр баригдсан сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Дэлгэр сум/- ХАА зарласан боловч оролцогч ирээгүй тул дахин зарлахаар шийдвэрлэсэн. ЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу санхүүжилт зогсоосон тул хэрэгжээгүй
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Төгрөг сум, Соёлын төвийн барилгын засвар/-2 удаа ХАА-г зарласан боловч оролцогч оролцоогүй. ЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу санхүүжилт зогсоосон тул хэрэгжээгүй
- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, БТСГ-ын их засвар/-ЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу санхүүжилт зогсоосон тул хэрэгжээгүй

ТАХ-ний гэрээний хэрэгжилтийн талаар:

22. Гүйцэтгэгч компаниас гэрээг сунгах үндэслэлтэй хүсэлт ирүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/672 тоот захирамжаар гэрээ сунгах эрх олгосон боловч гэрээнд сунгалт хийгдээгүй байна. Үүнд:

- ✓ Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/
- ✓ Сургуулийн дотуур байрны засвар /Говь-Алтай, Тайшир сум/

УТХО-аар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга байгууламжийн талаар:

23. УТХО-аар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга байгууламж байна. Тухайлбал:

- ✓ Сумын төвийн шинэчлэл /Говь-Алтай, Дэлгэр сум/- ТАХ-нд Дэлгэр сумын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө, айл өрх, албан байгууллагыг цэвэр, бохир ус, дулаанд холбох, цэвэрлэх байгууламжийг байгуулах 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Мандал голомт ХХК гүйцэтгэж байна. Тус ажил нь 2014 онд БХБ-ын сайдын 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 32 дугаар тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн. Гүйцэтгэгчийн зүгээс ажлаа эрчимжүүлэхгүй байгаа бөгөөд ковидын нөхцөл байдал нөлөөлсөн байна. -Дулааны шугам, барилгын ажил-шугамын ажил дууссан. 100 хувьтай.

-Цэвэр ус, гүний худаг-газар шорооны ажил хийгдсэн, худаг баригдсан-30 хувьтай

-Цэвэрлэх байгууламж, бохир усны шугам-Өмнө нь хийгдсэн боловч үерт өртөж хэрэгжилт хангалтгүй болсон.

-Цахилгаан холбооны шугам, үерийн хамгаалалт-Цахилгааны ажил 80 хувьтай, холбооны ажил дууссан. Үерийн хамгаалалт 30 хувьтай.

Одоогийн байдлаар нийт гүйцэтгэл 50 хувьтай гэж дүгнэсэн.

Барилгын хөгжлийн төвөөс санхүүжилтийг 100 хувь өгсөн гэж үзсэн. Гэрээний хугацаа дууссан.

2018.11.23-ны өдрийн нэмэлт гэрээний 9 дүгээр зүйлийн 9.3-т ажил дууссаны дараа үлдэгдэл /20 хувь/ санхүүжилтийг өгөхөөр заасан боловч БХБЯ-аас санхүүжилтийг бүрэн олгосон.

Зураг 1. Усан оргилуур

- ✓ Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /Говь-Алтай, Есөнбулаг/- Усан оргилуур, усан хангамжийн 176.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэхээр Ус-Алтай ХХК-тай гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгосон боловч хэрэгжээгүй байна. Говь-Алтай аймгийн иргэний хэргийн анхан шатны 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 133/ШШ2018/00567 дугаар бүхий шүүхийн шийдвэрээр ажлын дутууг хийж гүйцэтгүүлэх шаардлагыг хангаж баталаажуулсан байна. Улмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газартай 2019 оны 08 дугаар сарын 27-ний өдрийн 133/ГХ2019/00231 дугаар бүхий шүүхийн гүйцэтгэх хуудсаар ажлын дутууг хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулжээ. Гүйцэтгэгч зүгээс ажлаа гүйцэтгэхгүй байгаа бөгөөд шалтгаан тодорхойгүй байна.



- ✓ Жишиг гудамж, тохижилт /Говь-Алтай, Есөнбулаг сум/- Гэрээнд 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдөр хүртэл сунгалт хийсэн.
- ✓ 320 хүүхдийн сургуулийн барилга /Говь-Алтай, Дэлгэр сум/- Уг барилгын халаалтын зуухны барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулалт хүлээгдэж байгаа.
- ✓ Цэцэрлэгийн барилга, 100 ор, /Говь-Алтай, Халиун сум/- Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа гүйцэтгэхгүй байсан тул БШУЯ-аас 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 2/4250 дугаартай албан бичгээр гэрээг цуцласан. Дахин гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар хүлээгдэж байгаа. Яамнаас шүүхэд хандсан.
- ✓ Цэцэрлэгийн барилга 75 ор, /Говь-Алтай, Цээл сум/- Гадна дэд бүтцийн асуудал он дамнаж шийдвэрлэгдсэний улмаас хүлээгдэж байгаа.
- ✓ Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг, 4 дүгээр сургууль/- Ажлыг шалгуулахаар Цагдаагийн ерөнхий газарт хүсэлт гарган Зөрчлийн хэрэг нээсэн. 2020 онд гүйцэтгэгч ажлаа хийгээгүй.
- ✓ Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/- Санхүүжилт нь орон нутагт дундын /эксроу/ дансанд шилжүүлсэн. Суурийн цутгалт хийсэнд Зөрчлийн хэрэг нээж ул суурь хүртэл буулгалт хийж дахин цутгасан. Технологийн горимын дагуу түр зогссон. Гүйцэтгэгчээс шалтгаалсан.
- ✓ Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой/- Санхүүжилт нэмэгдүүлэхээр 2021 оны төсөвт тусгуулах хүсэлт илгээсэн. Технологийн горимын дагуу түр зогссон.

Зураг 2. Тонхил сумын спорт заал

- ✓ Тонхил сумын спорт заалны барилгыг 2017 онд Хүрээ овоо ХХК гүйцэтгэж аймгийн гамшигийн сангаас 70.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Төсвийн тухай хуулиар 2020 онд 200.0 сая төгрөгийг баталсан боловч худалдан авах ажиллагаа амжилтгүй болж хэрэгжээгүй байна.
- ✓ БХБ-ын сайдын багцаас 2019 онд сумын төвийн ундны усны гүний худаг, 6 ш /Говь-Алтай/ ТАХ-г "Соёл инжинеринг" ХХК гүйцэтгэсэн боловч Халиун сумын удирдлагаас ирсэн судалгаагаар 25.0 сая төгрөгийг худаг гаргахаар зарцуулсан боловч ус гараагүй, худаг гэх зүйл байхгүй, хүлээж авсан баримт материал байхгүй байна.





УТХО-аар 2016-2020 онд баригдаж ашиглалтад орсон ТАХ-ний ашиглалтын талаар:

24. УТХО-аар 2016-2020 онд баригдаж ашиглалтад орсон зарим барилга байгууламж чанаргүй хийгдсэн, ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал:

- ✓ БШУС-ын багцаас 3,581.6 сая төгрөгийн өртөгтэй “Урагшлах” ХХК гүйцэтгэсэн Баян-Уул сумын 640 суудлын ерөнхий боловсролын сургуулийг 2017 онд ашиглалт орсон. Дээрээс ус орж ангиудын дохиолол шатаж, цахилгааны монтаж гэмтсэн, спорт заалны дээвэр усны хаялга байхгүй, өнгөлгөөний тоосгоны өнгө хөвхорсон байна.

Зураг 3. Баян-Уул сумын сургуулийн барилга, дотор тааз, хана



- ✓ БШУС-ын багцаас 5,420.0 сая төгрөгийн өртөгтэй “Жинст Транс” ХХК гүйцэтгэсэн Есөнбулаг сумын 960 суудлын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийг 2019 онд ашиглалт орсон. Дээрээс урлагийн заал руу ус алдсан, суулт өгч цонх хагарснаар салхи шороо орох, дулаан алддаг, суулт өгснөөс шалтгаалж бохир дамжуулах шугам хагарч засварласан.
- ✓ БШУС-ын багцаас 5,888.2 сая төгрөгийн өртөгтэй “Манхан Уст” ХХК гүйцэтгэсэн Есөнбулаг сумын 960 суудлын Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай дахь салбар сургуулийг 2020 онд ашиглалт орсон. Гадна дотор талд хана хөндлөн болон босоо чиглэлээр хагарал үүссэн, цонх хагарсан, дулаан алдалттай, халаалтын дотоод систем алдаатай хийгдсэн, ариун цэврийн өрөөний халаалтын секц байхгүйгээс хөлдсөн, бохирын агаар сэлгэлтийн сэнс мултартч унасан, 10 өрөөний цахилгааны залуур шатсан, 3 давхрын өрөөнүүдэд дээрээс ус ордог, агааржуулалтаас ус гоожиж камерын өрөөний хана хөвцөрсөн, гадна талын хаалга эвдэрсэн, нийтийн бохирын хянахын цонх байхгүй, парпет төмөр салхинд урагдсан.

Зураг 4. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай дахь салбар сургуулийн барилга



- ✓ Шадар сайдын багцаас 1,380.7 сая төгрөгийн өртөгтэй “Агни трейд” ХХК гүйцэтгэсэн Есөнбулаг сумын Мэргэжлийн хяналтын газрын барилга байгууламжийг 2019 онд ашиглалтад орсон бөгөөд Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 08-07-033/24 “барилга ашиглалтын тухай” дүгнэлтээр “барилгын өрөө тасалгааны цонхны дулаалга, амлагааг хангалтгүй хийснээр тоос шороо ордог, лабораторийн хэсгийн орцны хэсгийг ажлын зургаас өөрчилсөн, хийж гүйцэтгээгүй, тагтны хэсэгт хагарал, ан цав үүссэн, барилгын ус зайлуулах бетон хаяавч суултад орсны улмаас эвдэрч гэмтсэн, зай завсар үүссэн, дотор гадна талд босоо болон хөндлөн хагарал үүссэн, ариун цэврийн өрөөнүүдийн тоног төхөөрөмж чанарын шаардлага хангахгүй, гражны дээрээс ус орсон, гадна талын цементэн талбайн шороо гарч ирсэн, цахилгааны ерөнхий самбар, лабораторийн орцны хэсгийг зураг төсвөөс өөр хийгдсэн” гэсэн байна.

Зураг 5. Мэргэжлийн хяналтын газрын барилга



- ✓ Есөнбулаг сумын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн засварыг 49.2 сая төгрөгөөр 2020 онд Орд Харш ХХК гүйцэтгэсэн. Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Барилгын засварын ажлын талаар” 01-07020/08/80/370 дугаар бүхий дүгнэлтээр “ангиудын бетон шалны тэгшилгээг сайтар хийгээгүйгээс шалны гадаргуугийн тэгш байдал алдагдсан, ширхгийн материал буюу зүймэл хулдаасан өнгөн үеийн элементүүдийн нийлж байгаа црмзгүүд зөрсөн” гэж дүгнэжээ. Бодит байдал дээр 2 ангийн шалны хулдаас хуйларч, хөвхорсон байна. Мөн ангийн засварыг хийх явцад тус сургуулийн гэрэл, цахилгаан, цэвэр усыг ашиглан гүйцэтгэсний төлбөр болох 1.0 сая төгрөгийн төлбөр тооцоог барагдуулаагүй, мөн 7.6 сая төгрөгийн шалны хулдаасыг зээлээр авч хэрэглэсэн боловч төлж барагдуулаагүй байна.
- ✓ БШУС-ын багцаас 1,400.0 сая төгрөгийн өртөгтэй “Аксу-Алтай” ХХК гүйцэтгэсэн Алтай сумын 240 суудлын ерөнхий боловсролын сургуулийг 2017 онд ашиглалт орсон. Сургуулийн гадна талын хана цуурсан, цонхоор шороо ордог, ариун цэврийн өрөөний нойл бөглөрдөг.



- ✓ БШУС-ын багцаас 1,899.3 сая төгрөгийн өртөгтэй “Цахиур толгойн орд” ХХК гүйцэтгэсэн Дарви сумын 320 суудлын ерөнхий боловсролын сургуулийг 2019 онд ашиглалт орсон. Цайны газрын цонх хагарсан, цонхны хавтангуудын дундуур ус ордог, ногоон байгууламж зурагт тусгагдсанаар хийгдээгүй, интернэтийн доголдол гарч ангиуд холбогддоггүй, гал тогооны уур сорогч шаардлага хангагдаагүй, зарим нойл, гар угаалтуур холбогдоогүй, дутуу ажилладаг.
- ✓ БШУС-ын багцаас 2,144.6 сая төгрөгийн өртөгтэй “Аз өрнөх” ХХК гүйцэтгэсэн Бигэр сумын 320 суудлын ерөнхий боловсролын сургуулийг 2020 онд ашиглалт орсон. Өвөлд их цантдаг хүйтэн, барилгын хана цуурсан.
- ✓ Соёлын сайдын багцаас 1,187.4 сая төгрөгийн өртөгтэй “Хонгор буурал” ХХК гүйцэтгэсэн Тайшир сумын Соёлын төвийн барилгыг 2017 онд ашиглалтад орсон. 2 давхарт цууралт өгсөн, дулаан алдалт ихтэй, дээрээс ус гоождог, ариун цэврийн өрөөний агааржуулалт хийгдээгүй, худгийн ус нөөцийн саванд ирээгүйгээс ариун цэврийн өрөө ашиглах боломжгүй. Гүйцэтгэгч компанид удаа дараа хүсэлт гаргасан боловч хүсэлтийн дагуу асуудлыг шийдвэрлээгүй.
- ✓ ЭМС-ын багцаас 1,289.0 сая төгрөгийн өртөгтэй “Арвин бэлт” ХХК гүйцэтгэсэн Дарви сумын эрүүл мэндийн төвийн барилгыг 2019 онд ашиглалтад орсон. Гадна талбайд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулаагүй.
- ✓ Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-4 /Говь-Алтай, Есөнбулаг/ -Тоглоомын талбай байгуулах 100.4 сая төгрөгийн ажлыг Ус-Алтай ХХК гүйцэтгэжээ. Гэвч чанаргүй гүйцэтгэж 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр дахин 262.9 сая төгрөгөөр тоглоом суурилуулах ажил хийгдэж байна.
- ✓ БШУС-ын багцаас 979.0 сая төгрөгийн өртөгтэй “Арвин өргөө констракшн” ХХК гүйцэтгэсэн Есөнбулаг сумын 100 орны цэцэрлэгийн барилгыг 2020 онд ашиглалтад орсон. Цонх хагарсан, дотор хананд цуурсан.
- ✓ БШУС-ын багцаас 5,494.0 сая төгрөгийн өртөгтэй “Заг” ХХК гүйцэтгэсэн Алтай чуулгын барилга 500 суудалтай барилга 2017 онд ашиглалтад орсон. Тус барилгын гадна хана цуурсан байна. Барилгын ашиглалтын нөхцөл байдлыг ирүүлэхийг байгууллагын удирдлага, нягтлан бодогчоос хүссэн боловч ирүүлээгүй болно.

Зураг 6. Солонго хорооллын зам

- ✓ БХБ-ын сайдын багцаас 5,814.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Орон сууцын хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Говь-Алтай, Есөнбулаг сум, Солонго хороолол/ ТАХ-г “Түмэндэлгэрэх” ХХК гүйцэтгэсэн. Ажлыг гүйцэтгэхдээ Солонго хорооллын засмал замыг сэтлэх зөвшөөрөл авч буцаан засварласан боловч шаардлага хангахгүй байна.



25. Тайлант онд хэрэгжсэн 36 ТАХ-ний явцад захиалагчийн төлөөлж аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас үе шатны хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна. Хэдийгээр хяналтыг тавьж ажилласан байх боловч боловсролын салбарт хэрэгжүүлсэн их засварын ажлуудын чанар байдал муу байгаа нь хяналт үр дүн багатай байгааг харуулж байна. Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийн их засвар, Тонхил сумын ЭМТ-ийн барилгын их засварын ажилд зохиогчийн зүгээс хяналт тавьж ажиллаагүй байна. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Бигэр сумын сургуулийн спорт заалны барилгын ажилд хяналт хийж Зөрчлийн хэрэг нээн суурийн цутгалтыг ул суурь хүртэл буулгалт хийлгүүлж дахин цутгуулсан байна.

УТХО-аар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн талаар:

26. УТХО-аар 2020 онд Говь-Алтай аймагт тоног төхөөрөмж нийлүүлэх 918.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ батлагдсанаас 280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ хэрэгжээгүй, 638.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-ний тухайд 637.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Үүнээс БШУЯ-наас 45 байгууллагад 295.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эрх шилжээгүй, улсын хэмжээнд бэлтгэн нийлүүлсэн ба хөрөнгийг хүлээн авч нягтлан бодох бүртгэлдээ бүртгэжээ.

УТХО-ын харилцах, нягтлан бодох бүртгэлийн талаар:

27. Аймгийн төрийн сангийн хөрөнгө оруулалтын дансанд ТЕЗ тус бүрээр нийт 2,507.8 сая төгрөгийн санхүүжилт орж ирснээс эрх шилжсэн ТАХ-г санхүүжүүлсэн. Үүнд:

- ✓ БШУС-ны багцаас 1,051.4 сая төгрөг
- ✓ ЗГХЭГД-ын багцаас 630.0 сая төгрөг
- ✓ ЭМС-ын багцаас 136.9 сая төгрөг
- ✓ БХБС-ын багцаас 157.2 сая төгрөг
- ✓ ХНХ-ын сайдын багцаас 50.0 сая төгрөг
- ✓ Сангийн сайдын багцаас 90.4 сая төгрөг
- ✓ Шадар сайдын багцаас 391.9 сая төгрөг



Хүснэгт 3. УТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэл /сая төгрөг/

№	ТЭЗ	Батлагдсан		2020.12.31-ны байдлаар			
		Төслийн тоо	Үүнээс 2020 онд дуусах	Гэрээний дүн	Нийт гүйцэтгэл	Гүйцэтгэл ийн хувь	Үлдэгдэл санхүүжилт
2	II. МУЕС	2	2	0.0	0.0		0.0
3	III. МУШС	2	2	394.1	391.9	99.4%	2.3
4	IV. МУСЭГХЭГД	2	2	1,129.9	1,125.8	99.6%	4.2
10	X. ХНХС	1	0	1,199.7	50.0	4.2%	1,149.7
11	XI. БХБС	5	3	352.1	157.2	44.6%	194.9
12	XII. БШУС	20	16	4,553.0	1,115.3	24.5%	3,437.7
13	XIII. СоС	1	0	219.9	50.0	22.7%	169.9
14	XIV. ЗТХС	1	0	76.7	0.0	0.0%	76.7
19	XVIII. ЭМС	2	2	141.4	136.9	96.8%	4.5
НИЙТ		36	27	8066.8	3027.1	38%	5039.8

Эх сурвалж: Говь-Алтай аймаг дахь Аудитын газар

УТХО-аар өмнөх оноос дамжин ирсэн болон 2020 онд эрх шилжин хэрэгжсэн 8,066.8 сая төгрөгийн гэрээний үнэтэй 29 ТАХ-нд 2019 онд 534.0 сая төгрөгийг, 2020 онд 2,493.1 сая төгрөг, нийт 3,027.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 5,039.8 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэлтэй байна.

28. Аймгийн төрийн сангийн хөрөнгө оруулалтын дансанд шилжиж ирсэн 2,507.8 сая төгрөгөөс тайлант хугацаанд 2,493.1 сая төгрөгийг зарцуулж 14.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж мөнгө татан төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 4. УТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэл /сая төгрөг/

№	ТЭЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гэрээний дүн	Үүнээс								Олгосон санхүүжилт			
						Санхүүжилтийн гүйцэтгэл		Ажлын бодит гүйцэтгэлээр		Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаагаар		Зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ		И баримттай	И баримтгүй		
						дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь				
2	II. МУЕС	2	290.0	290.0	0.0												
3	III. МУШС	2	1,380.7	398.1	394.1	391.9	99.4%	391.9	99%	0.00	0.00	0.00	0.00	-	-	391.9	
4	IV. МУСЭГХЭГД	2	1,130.0	630.0	1,129.9	1,125.8	99.6%	630.0	56%	0.00	0.00	0.00	0.00	-	-	1,125.8	
10	X. ХНХС	1	1,200.0	50.0	1,199.7	50.0	4.2%	50.0	4%	0.00	0.00	0.00	0.00	-	-	50.0	
11	XI. БХБС	5	444.6	294.6	352.1	157.2	44.6%	157.2	45%	0.00	0.00	0.00	0.00	-	-	157.2	
12	XII. БШУС	20	5,042.4	1,466.3	4,553.0	1,115.3	24.5%	1,077.0	24%	14.8	32%	0.00	0.00	189.3	-	926.0	
13	XIII. СоС	1	220.0	50.0	219.9	50.0	22.7%	50.0	23%	0.00	0.00	0.00	0.00	-	-	50.0	
14	XIV. ЗТХС	1	80.0	50.0	76.7	-	0.0%	-	0%	0.00	0.00	0.00	0.00	-	-	-	
19	XVIII. ЭМС	2	150.0	150.0	141.4	136.9	96.8%	136.9	97%	0.00	0.00	0.00	0.00	-	-	136.9	
НИЙТ		36.0	9,937.7	3,379.0	8066.8	3,027.1	38%	2,493.1	31%	14.8	0.2%	0.0	0.0	189.3	-	2,837.7	

Эх сурвалж: Говь-Алтай аймаг дахь Аудитын газар

29. Аудитаар ирүүлсэн баримтын хүрээнд авч үзэхэд гүйцэтгэгч ТАХ-ний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тодорхойлох боломжгүй, анхан шатны санхүүгийн баримтын бүрдлийг хангалтгүй бүрдүүлсэн байна. Тайлант онд 27 ТАХ-г гүйцэтгэхээр гэрээ байгуулсан гүйцэтгэгч нараас 4 аж ахуйн нэгж 189.3 сая төгрөгийн е-баримт ирүүлсэн бөгөөд 2,837.7 сая төгрөгийн зардлын баримт ирүүлээгүй байна.

30. Эрх шилжиж ирсэн 36 ТАХ-ээс бодитоор хэрэгжсэн 29 ТАХ-ний гэрээг үзэхэд нийт 104.6 сая төгрөгийг техник хяналтын зардалд, 69.9 сая төгрөгийг магадалшгүй ажлын зардалд, 151.5 сая төгрөгийг инженер хайгуулын зураг төсвийн үнэд, 54.2 сая төгрөгийг зохиогчийн хяналтын зардалд 9.8 сая төгрөгийг нормчлолын сангийн зардалд олгохоор заасан байна. Зарим ТАХ-ний төсөвт захиалагч, зохиогчийн хяналт хийх зардлыг тусгаагүй байна. Тухайлбал:

- ✓ Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /Говь-Алтай, Есөнбулаг сум/
- ✓ Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал, /Говь-Алтай, Есөнбулаг сум/

31. Тайлант онд орон нутгийн техник хяналтын зардлын дансанд 13 ТАХ-ний 59.3 сая төгрөгийг байршуулсан ба үүний 21.4 сая төгрөг нь зураг төсвийн үнэ, 33.7 сая төгрөг нь техник хяналтын зардал, 4.2 сая төгрөг нь зохиогчийн хяналтын зардал болно. Үүнээс тайлант хугацаанд 5.8 сая төгрөгийн зураг төсвийн үнийг шилжүүлжээ.

32. Техник хяналтын зардлын дансанд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 191.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүний 169.0 сая төгрөг нь техник хяналтын зардал, 8.8 сая төгрөг нь зохиогчийн хяналтын зардал, 14.1 сая төгрөг нь зураг төсвийн үнийн үлдэгдэл байна. Үүнийг хэрэгжсэн ТАХ-аар харахад ихэнх нь хэрэгжээд дууссан ажлын техник хяналтын зардлын үлдэгдэл байна. Гэтэл ГХБХБГ хяналт хийсэн ажлын тайлангаа бүрэн ирүүлээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс тус дансанд байрших техник хяналтын зардлаас хэдийг өгөх нь тодорхойгүй байна. Аудитаар ГХБХБГ-аас хяналт хийсэн



тайланг аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэн тооцоо нийлүүлэх гэсэн боловч энэ нь өмнөх онуудад хэрэгжсэн ТАХ-ний гэрээнд тусгагдсан хяналтын, зохиогчийн, зураг төсвийн зардал хэд байсныг нэг бүрчлэн тооцсоны үр дүнд энэ тооцоо хийгдэхээр байсан тул эцсийн тооцоо гарсангүй.

33. Техник хяналтын зардлын данснаас 44.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- ✓ ЗГХЭГ-ийн даргын багцаас Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилгын ТАХ-нд шилжүүлсэн санхүүжилтээс 23.9 сая төгрөгийг техник хяналтын зардлын дансанд төвлөрүүлэн нийт дүнгээр ГХБХБГ-т шилжүүлсэн боловч Барилгын хөгжлийн төвд 7.9 сая төгрөгийг зохиогчийн хяналтын зардалд 2020 оны 11 сард давхардуулан шилжүүлсэн.
- ✓ Техник хяналтын дансанд орлого оруулаагүй байтал 5,6,7,13,БУК-18,Эрчмийн 8 айлын орон сууцуудын гадна засвар магадалшгүй ажилд 1.2 сая төгрөгийг 2019 оны 12 сард Харшийн цуурай ХХК-д шилжүүлсэн.
- ✓ Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/49 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан "Захиалагчийн хяналт хийх, техник хяналтын зардлыг захиран зарцуулах журам"-ын дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/78 захирамжаар 16.5 сая төгрөгийн автомашин бэлтгэсэн. Энэ нь ямар ажлын ТАХ-ний захиалагчийн хяналтын зардлаас зарцуулсан нь тодорхойгүй байгаа ба уг асуудлаар аймгийн ЗДТГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/15 дугаар тушаалын дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллаж байна.
- ✓ Өмнөх онуудын гүйцэтгэлийн аудитаар тогтоогдсон алданги 18.9 сая төгрөгийг техник хяналтын зардлын данснаас төлжээ.

Иймд техник хяналтын зардлын дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хуулийн этгээдтэй тооцоо нийлж шийдвэрлэх шаардлагатай байна. Мөн хэрэгжсэн ТАХ болгоноор техник хяналтын зардлын тооцоог хийж тухай бүрд нь дуусгавар болгож байх нь зүйтэй юм.

34. Хэрэгжиж байгаа 3 ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 169.8 сая төгрөгөөр илүү олгосон.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-д заасны дагуу төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой. Гэвч дараах ажлуудын гүйцэтгэл, гэрээнд заасан санхүүжилтийн хуваарийг зөрчин санхүүжилтийг олгосон байна. Тухайлбал:

Зураг 7. Спорт заалны барилга

- ✓ Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний 16.2 дахь заалтад 70, 30 хувиар санхүүжүүлэхээр харилцан адилгүй гэрээ байгуулсан нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.5 дахь заалтыг зөрчсөн ба бодит гүйцэтгэлээс 40 хувь буюу 100.0 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн.
- ✓ Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний тухайд огт ажил хийгдээгүй байхад гүйцэтгэгч БГБС ХХК-д 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- ✓ Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух /Говь-Алтай, Цээл сум/ ТАХ-ний бодит гүйцэтгэл 70 хувьтай байхад 19.8 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн.



35. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан банкны баталгааг үндэслэн олгох, зарим зайлшгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулахаар ТЭЗ нарт даалгажээ. Тайлант онд барьцаа дансны хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 456.9 сая төгрөгийг он дамнуулж байршуулсан байна.

36. УТХО-аар 2020 онд ашиглалтад орсон 7 ТАХ-ний 15,241.9 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна. Тухайлбал:

- ✓ Цагдаагийн газрын барилгын 2,075.0 сая төгрөг
- ✓ Солонго хорооллын орон сууцын хорооллын гадна инженерийн шугам сүлжээ 5,814.3 сая төгрөг
- ✓ Аймгийн төвүүдийн үерийн хамгаалалт 1,334.4 сая төгрөг
- ✓ Анагаах ухааны үндэсний их сургуулийн харьяа Говь-Алтай аймаг дахь салбар сургуулийн 5,888.2 сая төгрөг
- ✓ Өрхийн эмнэлгийн автомашины 60.0 сая төгрөг
- ✓ Багийн эмчийн 39 мотоциплын үнэ 70.0 сая төгрөг



Ерөнхий Дүгнэлт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО АЛДАГДАЖ УЛМААР ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛСААР БАЙНА.

Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга нарт:

1. Сумдыг хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох асуудлыг шийдвэрлэх
2. Хот хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөөг батлуулах
3. УТХО-аар хэрэгцээ, шаардлагатай барилга байгууламжийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх
4. Техникийн тодорхойлолт дутуу төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байх

Татварын хэлтэст:

1. УТХО-ыг гүйцэтгэгч ААНБ-уудын нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд хяналт шалгалт хийж хариуг ирүүлэх

Санхүү, Төрийн сангийн хэлтэст:

1. Е баримтгүй гүйлгээ хийхгүй байх

АШУУИС-ийн Говь-Алтай дахь салбар сургуулийн захиралд:

1. Хууль эрх зүйн хүрээнд хөрөнгийг орлого авах асуудлыг шийдвэрлүүлэх

Орон нутгийн өмчийн газарт:

1. Төсөвт байгууллагуудын ашиглагдахгүй байгаа барилга байгууламжийн судалгааг гаргаж сум орон нутагт орлого оруулах, үр өгөөжийг бий болгох боломжийг судалж шийдвэрлэх
2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудыг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажлыг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах

Албан шаардлага

Аймгийн Засаг дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга нарт:

1. “Хуучин Алтай чуулгын барилгыг буулгаж газрыг дахин төлөвлөлтөд оруулах нь зүйтэй” гэсэн улсын байцаагчийн дүгнэлтийг харгалзан “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх арга хэмжээг дахин нягталж шийдвэрлэх
2. Салбарын хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулж, төсвийн багцад хэрэгжих төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлэн тусгах
3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан барилга байгууламжид төсөв батлан зарцуулж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байгаа төдийгүй хүний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдалд эрсдэл бий болж байгааг хянаж шийдвэрлэх
4. Дуусаагүй, орхигдсон төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг тавьж, хэрэгжилтийг хангуулан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний чанар байдалд хяналт хийж зөрчлийг арилгах
5. Техник хяналтын дансанд байгаа үлдэгдлийг гэрээний дагуу, нотлох баримтаар үндэслэн олгож, төсөл хөтөлбөрийн бодит гүйцэтгэлийг үндэслэж санхүүжүүлэх
6. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг тойм дүнгээр баталж хэрэгжүүлсэн, газрын асуудал шийдэгдээгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсвийг батлуулаагүй төсөл арга хэмжээг төсвийн төлөвлөлтөд оруулахгүй байх

ГХБХБГ-ын даргад:

1. “Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах



Уламжлах

ҮАГ-ын аудитын гуравдугаар газарт уламжлан нэгдсэн тайланд тусгаж харьяалах ТЕЗ-д зөвлөмж өгөх:

1. ТЕЗ-аас хүргүүлсэн төсвийн саналд тусгагдаагүй ТАХ-г батлахгүй байх, хөрөнгө оруулалтын бодлого, төсөв хоорондын уялдааг хангуулах
2. Эрх шилжүүлэх шийдвэр гаргахдаа төсөл арга хэмжээг тайлант онд хэрэгжиж болохуйц нөхцөлийг хангах
3. Хэрэгжээгүй орхигдсон ажлыг холбогдох ТЕЗ-д уламжлан шийдвэрлүүлэх
4. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан барилга байгууламжид төсөв батлан зарцуулж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байгаа төдийгүй хүний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдалд эрсдэл бий болж байгаа талаар нэгдсэн тайланд тусгаж харьяалах ТЕЗ-д зөвлөмж өгөх